



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠯᠢ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/293

Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/198 дугаар тушаалыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Төрийн өмчит цөм сүргийг бүрдүүлэх зорилгоор баталгаажсан үүлдэр, омгийн малын стандартын шаардлага хангасан бог малын хээлтүүлэгч нийлүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Т.Сүхбаатар (Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

С.Эрдэнэ-Очир (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга)

А.Сувданчимэг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хяналтын албаны мал үржлийн хяналтын улсын байцаагч)

2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан малын төрөл, тоо хэмжээ, төсөвт багтаан холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн бог малын хээлтүүлэгч худалдан авах ажлыг зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж, тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Т.Сүхбаатар)-д үүрэг болгосугай

3.Бог малын хээлтүүлэгчийг нийлүүлэх ажлын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР